



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 22 өдөр

Дугаар A/670

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн XII/21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Хульжийн рашааны хамгаалалтын бүсийг хашаажуулах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан "Бүлээн оргил" ХХК-тай 115 681 182 (Нэг зуун арван таван сая зургаан зуун наян нэг мянга нэг зуун наян хоёр) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Бүлээн оргил" ХХК-ийн захирал (Ж.Батжаргал)-д даалгасугай.

4. Тус ажлыг хууль, журам, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

5. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг холбогдох байгууллагын дарга нар т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны 09 сарын
22 өдрийн А/57 дугаар захирамжийн хавсралт



№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	1,925,355	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн албаны зардал	1,925,355	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	962,677	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул зураг төслийн ажлын дүн	4,800,000	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Хоногт гэрээний үнийн 0.1 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
6	Ажил гүйцэтгэх хугацаа	60 хоног	Ү.Бямбасүрэн